



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/89

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1"б", 29.1.1"а"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гурвансайхан сумын Салхитын мөнгөний орд дээр ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эрдэнэс силвер ресурс" ХХК-тай хамтран дэд бүтэц, нийгмийн тогтвортой хөгжил, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжихэд чиглэгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдан зохион байгуулах үүрэг бүхий сангийн ажиллах журмын төслийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга: П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд: А.Ганбат (Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)
Б.Түвшинбаяр (Хууль эрх зүйн хэлтсийн дарга)
Б.Мөнхжаргал (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Хоёр. Сан байгуулах, бүрдүүлэх хууль эрхзүйн орчинг судалж, сангийн ажиллах журам зэрэг холбогдох баримт бичгийг 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010268